

ДОТООДЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР



Оюунлаг хүмүүн
Монголын баялаг
2015-2016 он



ОЮУ ТОЛГОЙ ХХК МОНГОЛЫН ОЮУТАН ЗАЛУУСЫГ ДЭМЖИН МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТАЙ БАЙГУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ БОЛОН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМТАЙ БАЙГУУЛСАН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧГИЙН ХҮРЭЭНД ШИЛДЭГ ОЮУТАН ЗАЛУУСТ ЗОРИУЛСАН ДОТООДЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙГ 2010 ОНООС ЭХЛЭН АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.

ТЭТГЭЛЭГТ ДАРААХ ЗҮЙЛС БАГТАНА:

- Сургалтын төлбөр,
- Сар бүр 200.000 төгрөгийн тэтгэлэг,
- Хөдөө орон нутгийн оюутнуудын дотуур байрны төлбөр,
- “Оюу толгой” ХХК-аас хэрэгжүүлдэг хөгжлийн сургалтуудад хамрагдах,
- Тус компанид дадлага хийх боломж

ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ШАЛГУУР:

- Монгол улсын иргэн байх,
- Дотоодын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн 2, 3, 4 дүгээр дамжааны өдрийн ангийн оюутан байх,
- Уул уурхай, Металлурги, Баяжуулалт, Механик, Цахилгаан болон Барилгын инженер, Геологи, Геодези, Хими, Орчин ба хөдөлмөрийн эрүүл мэнд,

- Байгаль орчны чиглэлээр суралцаж байх (Уул уурхайн удирдлага мэргэжил хамаарахгүй),
- Сурлагын голч дүн 3.2 ба түүнээс дээш байх (4.0 хүртэлх томъёоллоор),
- Бусад тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаагүй байх.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

- Өргөдлийн маягт (www.ot.mn цахим хуудаснаас татаж аваад бүрэн гүйцэд бөглөнө үү),
- Зохион бичлэг (Одоо суралцаж байгаа мэргэжлээ яагаад сонгосон, сургуулиа төгсөөд эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу

хэрхэн ажиллахаар төлөвлөж байгаа, энэхүү зорилгодоо хүрэхийн тулд хэрхэн ажиллаж байгаа талаараа 500-600 үгэнд багтаан, Times New Roman 11 фондоор, мөр хоорондын зай 1.5-аар бичнэ.)

- Сургуулийн тодорхойлолт,
- Суралцсан хугацааны дүнгийн баталгаат хуулбар,
- Суралцсан хугацаанд гаргасан амжилт, авсан шагнал урамшууллын хуулбар,
- Иргэний үнэмлэхний хуулбар

ӨРГӨДӨЛ ХҮЛЭЭН АВАХ ЭЦСИЙН ХУГАЦАА: 2015-10-02-НЫ 17:00 ЦАГ

ӨРГӨДЛИЙН МАТЕРИАЛЫГ ДАРААХ ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ:

Улаанбаатар: “Оюу толгой” ХХК,
Улаанбаатар-13381, Баянзүрх
дүүрэг, 1-р хороо, Залуучуудын

өргөн чөлөө-26,
Сөүл Бизнес Төв – 7 давхар.
Утас: 331880 (3356, 3769)

- Анхан шатны шалгаруулалтад тэнцсэн оюутнуудыг ярилцлагад урина.
- Хугацаанаас хоцорсон болон дутуу бүрдүүлсэн материалыг хүлээж авахгүй.
- Ирүүлсэн материалыг буцаан олгохгүй.